

# “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 30-ны өдөр  
хот

№01

Улаанбаатар

## Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцох тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалт, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.21 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн саналын эрхтэй 551485 ширхэг хувьцааны эзэмшигчид буюу нийт хувьцааны 89,73 %-ийг эзэмшигчид хүрэлцэн ирсэн тул хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ш.ЭНХТӨР



# “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи  
ТҮЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэнд үндсэн дээр 2024 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс “2023 онд төлөвлөгөөний дагуу үр дүнтэй ажилласан” гэсэн дүгнэлтийг Хавсралт-1 ёсоор баталсугай.

ХОЁР: “Дархан гурил тэжээл” ХК-ийн өнөөдрийг хүртэл бий болгосон орчин үеийн техник, технологи бүхий үйлдвэрлэлийн нөөц боломж, үл хөдлөх хөрөнгө, газар, инженерийн дэд бүтцийг түшиглэн тус компанийн үйл ажиллагааг идэвхжүүлэн өргөжүүлэх оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ш.ЭНХТӨР



## “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 30-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан  
ТУЗ-ийн шийдвэрийг батлах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.9 дэх заалтуудыг тус тус удирдлага болгон 2023 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

НЭГ: “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг баталсугай.

ХОЁР: “Дархан гурил тэжээл” ХК нь 2022 онд зардлаа нөхөж чадаагүй, алдагдалтай байгаа болон Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1, 47.1.2 дугаар заалтад заасан нөхцөлүүдийг хангахгүй байгаа тул хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

ХУРЛЫН ДАРГА

Ш.ЭНХТӨР



## “ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 30-ны өдөр

№04

Улаанбаатар хот

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг улируулан сонгох тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, 77.2 дахь хэсэг, “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсгийг тус тус удирдлага болгон хэлэлцэний үндсэн дээр 2024 оны 4 сарын 30-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг үндэслэн ТОГТООХ нь:

- “Дархан гурил тэжээл” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дараах ердийн болон хараат бус гишүүдийн бүрэн эрхийг 3 (гурван) жилийн хугацаагаар сунгаж, улируулан сонгосугай.
- Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд:
  - Ш.Энхтөр
  - Д.Балдан-Очир
  - Б.Түвшинтер
  - Б.Түвшинжаргал
  - С.Энхтайван
  - Б.Бадрал
- Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд:
  - Ё.Амаржаргал
  - П.Мандахнаран
  - Н.Ариунтунгалаг
- Сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн дүрэм, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бусад дүрэм, журмыг мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ш.ЭНХТӨР